



**УЛСЫН ХОЁРДУГААР  
ТӨВ ЭМНЭЛЭГ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308  
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

2024.02.29 № 9/185  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх нь

20240102001/01/01 урилгын дугаар бүхий тендерт багц 31 “Тодосгогч бодис компьютер-1”-н Ионт бус иодот тодосгогч бодисын тунгийн хэмжээ 370мг/мл-100 мл байгаа ба эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус эмнэлэг нь шинээр “Зүрхний титэм судасны компьютер томографи” оношилгоонд ашиглахаар захиалсан болно.

Дэлхий дахинд 1990 оноос хойш тодосгогч бодисыг эмнэлгийн практикт хэрэглэж эхэлсэн ба ионы бус усанд уусдаг тодосгогч бодисуудыг толгойн, цээжний, хэвлийн, аарцгийн хөндийн, зүрх судасны ба судасны томографи шинжилгээнүүдэд ашиглаж байна. Энэ бодисын хувьд олон улсад 150-400 мг/мл тунтай үйлдвэрлэгддэг ба өвчтөний биеийн жин, нас махбодын болон хийгдэж байгаа шинжилгээний онцлогт тохируулан хэрэглэгддэг. Ионы бус тодосгогч бодисууд нь цусны сийвэнгийн уураг, биомембранд нөлөөлөх нь бага, 24 цагийн дотор 92 хувь нь шээсээр бүрэн ялгардаг, харьцангуй гаж нөлөө бага.

Олон судалгаа шинжилгээнээс харахад аппарат тоног төхөөрөмжийн зүслэгийн төрөл, чадавхиас хамааран 270-400 мг иодын агууламжтай бодисыг хэрэглэхийг зөвлөдөг. Олон улсад “Зүрхний титэм судасны компьютер томографи” оношилгоонд иодын агууламж өндөртэй буюу 320–400 мг/мл-г ихэвчлэн хэрэглэдэг байна.

Бид зүрхний титэм судасны компьютер томографи оношилгоонд тухайн эд дэх эмгэг ба судасны сүүдрийг тодруулах зорилгоор хэрэглэгддэг ионт бус иодот тодосгогч бодисыг ашиглах ба аппарат тоног төхөөрөмжийн чадал, бодисын тунгийн хэмжээнээс зургийн чанар хамаардаг тул монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн хамгийн өндөр тунтай тодосгогч бодисыг хэрэглэн оношилгооны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.

Жич: Тус эмнэлгийн өндөр өртөгт эмнэлгийн хэрэгслийн тендерээр Ионт бус иодот тодосгогч бодис 350 мг/мл-100 мл тодосгогч бодисыг худалдан авахаар төлөвлөж байгаа тул тус тендерт оролцож болно.

ЗАХИРАЛ

Б. БЯМБАДОРЖ

